



2005 он 05 сар 20 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

**Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас зээл авах зөвшөөрөл олгох,
дэмжин баталгаажуулах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл болон Говь ХК (“Компани”)-ийн дүрмийн 6.2.7 дах заалтыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (“ЕСБХБ”)-аас 10,000,000 (арван сая) ам.долларын зээлийг [3] жилийн хугацаатай, ЕСБХБ-ны санхүүжилтийн зардал +3.94-4.44% маржин хүүгийн нөхцөлтэйгөөр зээлж, холбогдох зээлийн гэрээг байгуулахыг Компанид зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын Хавсралт 1-д заасан хөрөнгийг ЕСБХБ-тай байгуулах зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийн баталгаа болгож барьцаанд тавих, барьцаа хөрөнгө нэмэгдүүлэх бол өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх, үүнтэй холбоотой дараах барьцааны гэрээнүүдийг байгуулах эрхийг Компанийн Санхүү Удирдлага хариуцсан захирал /Б.Хангалан/-д олгосугай.
Үүнд:
 - газар эзэмших эрхийн барьцааны гэрээ;
 - үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ (барилга); болон
 - хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ;
3. Энэхүү тогтоолын 1 болон 2 дахь заалтад дурдсан, ЕСБХБ-тай байгуулах гэрээнүүд болон холбогдох бусад гэрээ, баримт бичгийн нөхцөл, агуулгыг Компанийн нэрийн өмнөөс хэлэлцэн тохиролцож, улмаар Компанийг төлөөлж гарын үсэг зурж, баталгаажуулах, эдгээр гэрээтэй холбоотой мэдэгдэл, баталгаа, гэрчилгээ, маягт, хавсралт болон бусад баримт бичигт гарын үсэг зурах, холбогдох төлбөр тооцоог хийх эрхийг Санхүү Удирдлага хариуцсан захирал /Б.Хангалан/-д олгосугай.
4. Энэхүү тогтоол батлагдахаас өмнө ЕСБХБ-тай байгуулах зээлийн гэрээтэй холбоотой Компанийн Санхүү Удирдлага хариуцсан захирлын гаргасан аливаа бүх шийдвэр, үйлдэл нь энэхүү тогтоол батлагдсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр болохыг үүгээр дэмжин баталсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Ц.БААТАРСАЙХАН


Б.АМАРСАЙХАН

Д.ГЭРЭЛМАА

2025 он 05 сар 30 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

		А.ЖАРГАЛМАА
		Б.ОРГИЛ
		Ц.ОРГИЛБОЛД
		Д.ХУЛАН
		Д.ХҮРЭЛБААТАР
		Б.ЦЭЭНЯМ